

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Баянгол сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2026/103/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Б.Батмөнх
Сүхбаатар сум	Утас: 7036-3040 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn
2026 он	Ахлах аудитор: Ц.Отгонбаяр
	Утас: 7036-3036 Цахим хаяг: Otgonbayarts@audit.gov.mn
	Ахлах аудитор: Т.Болор
	Утас: 7036-2442 Цахим хаяг: bolort@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН БАЯНГОЛ
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Б.БАЯРМАА ТАНАА

2026.02.25 № СЭА-2026/703/НА-СТА-ТМЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Баянгол сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Баянгол сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Баянгол сумын ЭМТ нь ЭМС-ын 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн А/230 дугаар тушаалаар 2 жилийн хугацаагаар магадлан итгэмжлэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Баянгол сумын ЭМТ нь Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан "Сэлэнгэ аймгийн төсөвт байгууллагууд дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдөж байгаа бөгөөд уг

4326050127

бодлого нь эрүүл мэндийн салбарын гүйцэтгэлээр санхүүжиж байгаа үйл ажиллагааны онцлог, холбогдох хууль тогтоомжид нийцэхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Баянгол сумын Эрүүл мэндийн төв нь тайлант онд 5 зорилт, 120 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 99.2 хувийн биелэлттэй тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БАТМӨНХ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	649,711,744.60	682,730,043.03
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	118,901,933.48	262,422,276.83
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	118,901,933.48	262,422,276.83
31210	Төгрөг	118,901,933.48	262,422,276.83
31211	Төрийн сангийн харилцах	118,901,933.48	262,422,276.83
33	АВЛАГА	459,080,612.52	346,912,857.12
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	450,997,965.52	330,316,667.43
33500	Бусад авлага	8,082,647.00	16,596,189.69
33510	Байгууллагаас авах авлага	8,082,647.00	16,596,189.69
35	БАРАА МАТЕРИАЛ	71,729,198.60	73,394,909.08
35100	Түүхий эд материал	17,631,734.41	18,711,770.39
35130	Эм боох материал	17,631,734.41	18,711,770.39
35300	Бэлэн бүтээгдэхүүн	23,304,093.92	21,715,531.26
35400	Хангамжийн материал	30,793,370.27	32,967,607.43
35410	Бичиг хэргийн материал	241,800.00	213,900.00
35420	Аж ахуйн материал	273,000.00	131,500.00
35460	Хүнсний материал	2,100,665.00	2,889,000.00
35470	Бусад хангамжийн материал	28,177,905.27	29,733,207.43
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,093,207,648.77	969,283,575.65
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,093,207,648.77	969,283,575.65
39200	Биет хөрөнгө	1,073,456,148.77	949,532,075.65
39201	Барилга, байгууламж, орон сууц	704,466,147.92	704,466,147.92
39202	Хуримтлагдсан элэгдэл	(86,646,938.36)	(105,314,807.36)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	273,860,000.00	191,860,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(78,478,429.38)	(73,853,983.24)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	212,356,480.76	215,263,896.76
39206	Хуримтлагдсан элэгдэл	(145,026,105.98)	(180,665,639.47)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	199,739,073.62	206,691,497.98
39208	Хуримтлагдсан элэгдэл	(11,988,583.16)	(13,127,865.23)
39214	Бусад үндсэн хөрөнгө	9,347,145.00	7,974,875.50
39215	Хуримтлагдсан элэгдэл	(4,172,641.65)	(3,762,047.21)
39300	Биет бус хөрөнгө	19,751,500.00	19,751,500.00
39301	Програм хангамж	1,350,000.00	1,350,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(912,500.00)	(912,500.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	19,314,000.00	19,314,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	1,742,919,393.37	1,652,013,618.68
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	5,909,312.22	1,298,997.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5,909,312.22	1,298,997.00
41300	Өглөг	5,909,312.22	1,298,997.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	5,909,312.22	1,298,997.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,737,010,081.15	1,650,714,621.68
51	Засгийн газрын хувь оролцоо	1,737,010,081.15	1,650,714,621.68
51100	Засгийн газрын оруулсан капитал	192,285,530.00	192,285,530.00
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	192,285,530.00	192,285,530.00
51200	Хуримтлагдсан үр дүн	1,323,272,711.82	1,241,168,777.78
51210	Өмнөх үеийн үр дүн	984,775,385.46	1,323,272,711.82
51220	Тайлант үеийн үр дүн	338,497,326.36	(82,103,934.04)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	221,451,839.33	217,260,313.90

6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	1,742,919,393.37	1,652,013,618.68
---	--	------------------	------------------

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	1,887,191,587.25	1,799,233,909.97
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	347,531,081.00	1,799,233,909.97
120	Нийтлэг татварын бус орлого	347,531,081.00	282,792,635.82
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	190,693,996.80	278,872,876.17
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	190,693,996.80	278,872,876.17
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	152,463,000.00	3,499,100.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	4,374,084.20	420,659.65
122	Тусламжийн орлого	-	1,516,441,274.15
1221	Хандив тусламж /дотоод/	-	1,516,441,274.15
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	62,294,582.35
122111	Урсгал санхүүжилтийн орлого\	-	62,294,582.35
12215	Төсөв хоорондын хандив, тусламж	-	1,454,146,691.80
122151	Улсын эмнэлгүүдэд ЭМДС-с олгох шилжүүлгийн орлого \ЭМДС-УТ\	-	1,454,146,691.80
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,539,660,506.25	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	56,080,405.41	-
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	56,080,405.41	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,483,580,100.84	-
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,483,580,100.84	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,548,694,260.89	1,881,337,844.01
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,548,694,260.89	1,881,337,844.01
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,548,694,260.89	1,870,737,844.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	871,615,789.38	994,536,354.05
210101	Үндсэн цалин	490,335,138.19	617,937,302.96
210102	Нэмэгдэл	301,448,451.13	304,935,998.09
210103	Унаа хоолны хөнгөлөлт	18,671,207.00	23,054,180.00
210104	Урамшуулал	61,160,993.06	48,608,873.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	90,524,392.67	122,856,587.44
210201	Тэтгэврийн даатгалын зардал	50,863,845.85	84,707,032.46
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	7,778,557.97	9,949,383.67
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	3,891,188.03	6,021,500.77
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	3,646,066.86	4,300,844.45
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	24,344,733.96	17,877,826.09
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	66,491,974.60	57,294,582.35
210301	Гэрэл, цахилгаан	9,519,818.92	12,939,395.86
210302	Түлш, халаалт	55,233,355.68	42,616,386.49
210303	Цэвэр, бохир ус	1,738,800.00	1,738,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	46,965,860.00	60,789,000.00
210401	Бичиг хэрэг	3,802,300.00	6,247,700.00
210402	Тээвэр, шатахуун	36,287,740.00	44,045,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,107,820.00	2,210,100.00

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	600,000.00	1,486,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,168,000.00	6,799,700.00
2105	Нормативт зардал	337,711,141.68	417,432,131.22
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	318,388,856.68	394,927,081.22
210502	Хоол, хүнс	15,864,085.00	17,701,550.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,458,200.00	4,803,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,093,035.20	84,842,605.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,420,258.55	17,098,605.00
210602	Тавилга	-	7,385,900.00
210604	Урсгал засвар	18,672,776.65	60,358,100.00
2107	Томилолт, зочны зардал	4,830,300.00	6,040,500.00
210702	Дотоод албан томилолт	4,830,300.00	6,040,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,983,224.00	2,052,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,983,224.00	2,052,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	105,478,543.36	124,893,483.95
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,986,696.74	17,329,742.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	83,491,846.62	107,563,741.95
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	10,600,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	10,600,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	8,400,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	2,200,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	338,497,326.36	(82,103,934.04)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	338,497,326.36	(82,103,934.04)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,312,098,904.53	1,919,966,963.06
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	190,693,996.80	1,919,966,963.06
120	Нийтлэг татварын бус орлого	190,693,996.80	280,171,873.17
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	190,693,996.80	278,872,876.17
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	190,693,996.80	278,872,876.17
120015	Даатгалын нөхвөрөөс хилээн авсан мөнгө /ТӨҮГ/	-	1,298,997.00
122	Тусламжийн орлого	-	1,639,795,089.89
1221	Хандив тусламж /дотоод/	-	1,639,795,089.89
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	64,967,100.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого\	-	64,967,100.00
12215	Төсөв хоорондын хандив, тусламж	-	1,574,827,989.89
122151	Улсын эмнэлгүүдэд ЭМДС-с олгох шилжүүлгийн орлого \ЭМДС-УТ\	-	1,574,827,989.89
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,121,404,907.73	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	56,080,405.41	-
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	56,080,405.41	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,065,324,502.32	-
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,065,324,502.32	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,446,559,613.40	1,776,446,619.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,446,559,613.40	1,776,446,619.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,446,559,613.40	1,763,174,102.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	871,615,789.61	994,536,354.05
210101	Үндсэн цалин	498,035,327.08	617,937,302.96
210102	Нэмэгдэл	293,526,262.24	304,935,998.09
210103	Унаа хоолны хөнгөлөлт	18,893,207.00	23,054,180.00
210104	Урамшуулал	61,160,993.29	48,608,873.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	109,787,261.35	122,856,587.44
210201	Тэтгэврийн даатгалын зардал	76,930,552.67	84,707,032.46
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	9,151,146.92	9,949,383.67
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	4,780,026.15	6,021,500.77
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	3,716,085.92	4,300,844.45
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	15,209,449.69	17,877,826.09
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	53,875,005.41	57,294,582.35
210301	Гэрэл, цахилгаан	9,519,818.92	12,939,395.86
210302	Түлш, халаалт	42,616,386.49	42,616,386.49
210303	Цэвэр, бохир ус	1,738,800.00	1,738,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	48,460,560.00	60,789,000.00
210401	Бичиг хэрэг	3,622,100.00	6,247,700.00
210402	Тээвэр, шатахуун	36,388,140.00	44,045,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,107,820.00	2,210,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,121,300.00	1,486,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,221,200.00	6,799,700.00
2105	Нормативт зардал	332,576,313.03	417,432,131.22
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	316,472,463.03	394,927,081.22
210502	Хоол, хүнс	14,754,650.00	17,701,550.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,349,200.00	4,803,500.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,921,760.00	84,842,605.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	17,098,605.00
210602	Тавилга	-	7,385,900.00
210604	Урсгал засвар	14,921,760.00	60,358,100.00
2107	Томилолт, зочны зардал	4,764,300.00	6,040,500.00
210702	Дотоод албан томилолт	4,764,300.00	6,040,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,644,224.00	2,052,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,644,224.00	1,574,780.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	250,020.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	227,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,914,400.00	17,329,742.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,914,400.00	17,329,742.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	13,272,517.65
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	2,672,517.65
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	2,672,517.65
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	2,672,517.65
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\	-	2,672,517.65
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	10,600,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	8,400,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	2,200,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	(134,460,708.87)	143,520,343.35
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	22,564,000.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	22,564,000.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	22,564,000.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	22,564,000.00	-
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(22,564,000.00)	-
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(157,024,708.87)	143,520,343.35
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	275,926,642.35	118,901,933.48
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	118,901,933.48	262,422,276.83

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	192,285,530.00	221,451,839.33	984,775,385.46	1,398,512,754.79
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	192,285,530.00	221,451,839.33	984,775,385.46	1,398,512,754.79
9	Тайлант үеийн үр дүн	-	-	338,497,326.36	338,497,326.36
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	192,285,530.00	221,451,839.33	1,323,272,711.82	1,737,010,081.15
11	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	192,285,530.00	221,451,839.33	1,323,272,711.82	1,737,010,081.15
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	192,285,530.00	221,451,839.33	1,323,272,711.82	1,737,010,081.15
19	Тайлант үеийн үр дүн	-	(4,191,525.43)	(82,103,934.04)	(86,295,459.47)
20	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	192,285,530.00	217,260,313.90	1,241,168,777.78	1,650,714,621.68

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	2,438,268,100.00	1,915,995,448.41	522,272,651.59	78.58
12	Татварын бус орлого	2,438,268,100.00	1,915,995,448.41	522,272,651.59	78.58
120	Нийтлэг татварын бус орлого	338,028,900.00	278,872,876.17	59,156,023.83	82.50
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	338,028,900.00	278,872,876.17	59,156,023.83	82.50
122	Тусламжийн орлого	2,100,239,200.00	1,637,122,572.24	463,116,627.76	77.95
122001	Хандив тусламж /дотоод/	2,035,272,100.00	1,574,827,989.89	460,444,110.11	77.38
122005	Төсвөөс санхүүжих	64,967,100.00	62,294,582.35	2,672,517.65	95.89
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,557,169,800.00	1,773,774,102.06	783,395,697.94	69.36
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,557,169,800.00	1,773,774,102.06	783,395,697.94	69.36
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,536,207,300.00	1,763,174,102.06	773,033,197.94	69.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,491,954,200.00	994,536,354.05	497,417,845.95	66.66
210101	Үндсэн цалин	744,346,500.00	617,937,302.96	126,409,197.04	83.02
210102	Нэмэгдэл	544,807,700.00	304,935,998.09	239,871,701.91	55.97
210103	Унаа хоолны хөнгөлөлт	48,400,000.00	23,054,180.00	25,345,820.00	47.63
210104	Урамшуулал	154,400,000.00	48,608,873.00	105,791,127.00	31.48
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	186,144,200.00	122,856,587.44	63,287,612.56	66.00
210201	Тэтгэврийн даатгал	125,682,700.00	84,707,032.46	40,975,667.54	67.40
210202	Тэтгэмжийн даатгал	15,115,400.00	9,949,383.67	5,166,016.33	65.82
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,557,600.00	6,021,500.77	1,536,099.23	79.67
210204	Ажилгүйдлийн даатгал	7,557,600.00	4,300,844.45	3,256,755.55	56.91
210205	Эрүүл мэндийн даатгал	30,230,900.00	17,877,826.09	12,353,073.91	59.14
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	59,967,100.00	57,294,582.35	2,672,517.65	95.54
210301	Гэрэл, цахилгаан	15,612,000.00	12,939,395.86	2,672,604.14	82.88
210302	Түлш, халаалт	42,616,300.00	42,616,386.49	(86.49)	100.00
210303	Цэвэр, бохир ус	1,738,800.00	1,738,800.00	-	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	95,273,900.00	60,789,000.00	34,484,900.00	63.80
210401	Бичиг хэрэг	11,700,000.00	6,247,700.00	5,452,300.00	53.40
210402	Тээвэр, шатахуун	57,224,000.00	44,045,500.00	13,178,500.00	76.97
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,249,900.00	2,210,100.00	1,039,800.00	68.01
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,900,000.00	1,486,000.00	4,414,000.00	25.19
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	17,200,000.00	6,799,700.00	10,400,300.00	39.53
2105	Нормативт зардал	515,963,100.00	417,432,131.22	98,530,968.78	80.90
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	478,084,100.00	394,927,081.22	83,157,018.78	82.61

210502	Хоол, хүнс	24,980,000.00	17,701,550.00	7,278,450.00	70.86
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	12,899,000.00	4,803,500.00	8,095,500.00	37.24
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	134,000,000.00	84,842,605.00	49,157,395.00	63.32
210601	Багаж, техник, хэрэгсэл	41,000,000.00	17,098,605.00	23,901,395.00	41.70
210602	Тавилга	12,500,000.00	7,385,900.00	5,114,100.00	59.09
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	7,000,000.00	-	7,000,000.00	-
210604	Урсгал засвар	73,500,000.00	60,358,100.00	13,141,900.00	82.12
2107	Томилолт, зочны зардал	7,510,000.00	6,040,500.00	1,469,500.00	80.43
210702	Дотоод албан томилолт	7,510,000.00	6,040,500.00	1,469,500.00	80.43
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,189,900.00	2,052,600.00	10,137,300.00	16.84
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,149,900.00	1,574,780.00	2,575,120.00	37.95
210803	Даатгалын үйлчилгээ	1,000,000.00	250,020.00	749,980.00	25.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,000,000.00	227,800.00	772,200.00	22.78
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	440,000.00	-	440,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,600,000.00	-	5,600,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,204,900.00	17,329,742.00	15,875,158.00	52.19
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	33,204,900.00	17,329,742.00	15,875,158.00	52.19
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,962,500.00	10,600,000.00	10,362,500.00	50.57
2132	Бусад урсгал шилжүүлэг	20,962,500.00	10,600,000.00	10,362,500.00	50.57
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	16,800,000.00	8,400,000.00	8,400,000.00	50.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,162,500.00	2,200,000.00	1,962,500.00	52.85
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	(118,901,700.00)	142,221,346.35	(261,123,046.35)	(119.61)
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	118,901,700.00	(142,221,346.35)	261,123,046.35	(119.61)
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	118,901,700.00	(142,221,346.35)	261,123,046.35	(119.61)
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	118,901,933.48	(118,901,933.48)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	262,422,276.83	(262,422,276.83)	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	57.00	53.00	4.00	92.98
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	28.00	26.00	2.00	92.86
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00

620002	Гүйцэтгэх ажилтан	20.00	18.00	2.00	90.00
620003	Үйлчлэх ажилтан	7.00	7.00	-	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	28.00	26.00	2.00	92.86
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	21.00	21.00	-	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	7.00	5.00	2.00	71.43

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **3,228,094.3** мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг залрууллаа.

Залруулсан алдаа:

1. 2025 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бэлтгэж, 1,915,995.4 мянган төгрөгийг тайлагнаагүй нь УСНББОУС 24, “Санхүүгийн Тайлан дахь Төсвийн Мэдээллийн Толилуулга”-ын 14 дэх “байгууллага нь олон нийтийн өмнө хариуцах төсвийн дүн ба гүйцэтгэлийн дүн хоорондох зэрэгцүүлэлтийг тусад нь нэмэлт санхүүгийн тайлан байдлаар ...” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн “Толилуулга” батламж мэдэгдлийг хангахгүй байна.
2. Санхүүгийн үр дүнгийн болон мөнгөн гүйлгээний тайлангийн өмнөх оны үзүүлэлт 1,312,098.9 мянган төгрөгийг илэрхийлээгүй нь УСНББОУС 1, “Санхүүгийн Тайлангийн Толилуулга”-ын 53 дахь “байгууллага хамгийн наад зах нь, өмнөх тайлант үеийн зэрэгцүүлэгдэх мэдээллийн хамтаар санхүүгийн байдлын нэг тайлан, ... холбогдох тодруулгыг толилуулна.” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн “Толилуулга” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт **27,215.7** мянган төгрөгийн зөрчил² илэрч, **3,961.2** мянган төгрөгийн төлбөрийн акт, **2,955.0** мянган төгрөгийн албан шаардлага, **20,299.5** мянган төгрөгийн **1** зөвлөмж хүргүүлээ.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс **6,916.2** мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс **8,009.9** мянган төгрөгөөр бага тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

1. Төлбөрийн акт:

1. Эмийн сангийн борлуулалтын орлогыг **3,961.2** мянган төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2 дахь “Төсвийн байгууллага нь төвлөрүүлсэн төсвийн орлого болон өөрийн үйл ажиллагааны орлогыг Төрийн сангийн нэгдсэн дансанд саадгүй байршуулна.”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Дутуу төвлөрүүлсэн орлогыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2. Албан шаардлага:

1. Батлагдсан төсвийг зориулалт бусаар зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй дараах **955.0** мянган төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнд:

- Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас **450.0** мянган төгрөгийн санхүүгийн программын ашиглалтын төлбөр,
- Урсгал засварын батлагдсан төсвөөс **505.0** мянган төгрөгийн компьютер засварын үнийг шилжүүлсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*” гэж заасныг болон Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зориулалтын дагуу зарцуулж, үнэн зөв тайлагнаж байх албан шаардлага хүргүүлэв.

2. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлэлгүйгээр анхан шатны баримтын бүрдэл дутуу баримт материалыг үндэслэн ажил гүйлгээг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

- Шатахууны тайланд спидометрийн заалтыг зөрүүтэй тусгасан, жолооч хүлээн авсан шатахууны хэмжээгээр зарцуулалтыг гаргасан, нягтлан бодогч тухай бүр тооцоог хийж, хэтрэлт хэмнэлтийг гаргаагүй,
- Хүнсний материалын болон эмийн тайланд орлого, зарцуулалтыг зөрүүтэй илэрхийлсэн.

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь “*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.2 дахь “Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд “Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлнэ” гэсэн заалтын дагуу нягтлан бодогч Д.Ууганмаад сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

3. Аймгийн ЭМГ-аас хийсэн хяналт шалгалтаар дотоод хяналтын журмыг мөрдөөгүй зөрчилд 1,000.0 мянган төгрөг, ЭЭХХЗГ-аас хийсэн хяналт шалгалтаар мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн бүртгэл дутуу, бүрэн гүйцэт бүртгээгүй гэх үндэслэлээр 3,000.0 мянган төгрөг, нийт 4,000.0 мянган төгрөгийн торгууль ногдуулсан байна. Уг торгуулиас 2,000.0 мянган төгрөгийг зөрчил гаргасан албан тушаалтнуудаар төлүүлж, **2,000.0** мянган төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардлын батлагдсан төсвөөс төлж, төсвийн хөрөнгийн зориулалт бусаар, үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалт болон Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил гаргасан албан хаагчид хариуцлага тооцож, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, үнэн зөв тайлагнаж байх албан шаардлага хүргүүлэв.

3. Зөвлөмж

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал:

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн ангилалд ашиглаж байгаа боловч үлдэх өртөг “0” болсон 20,299.5 мянган төгрөгийн 44 нэр төрлийн хөрөнгийг дахин үнэлж бүртгээгүй, шинэчлэн тогтоох саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь “илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох”, УСНББОУС-17 “Үндсэн хөрөнгө”-ийн 49 дэх “... дахин үнэлэгдсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь дансны үнээсээ материаллаг ялгаатай байвал цаашид дахин үнэлэх зайлшгүй шаардлагатай” гэсэн заалтуудтай нийцээгүй бөгөөд “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Дээрх “0” үлдэгдэлтэй хөрөнгийг цаашид ашиглах бол дахин үнэлэх эсвэл акталж устгах асуудлыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх.

Дээрх **зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг** Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5³-д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

³ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

Батлагдсан төсвийг зориулалт бусаар зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй.	1	955.0			1	955.0					
Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлэлгүйгээр анхан шатны баримтын бүрдэл дутуу баримт материалыг үндэслэн ажил гүйлгээг хийж гүйцэтгэсэн.	1	-						1	1		
Хяналт шалгалтаар илэрсэн зөрчилд ногдуулсан төлбөрийг байгууллагаас барагдуулсан.	1	2,000.0			1	2,000.0					
Үлдэх өртөг "0" болсон 44 нэр төрлийн хөрөнгийг ашиглаж байна.	1	20,299.5					1	20,299.5			
Дүн	5	27,215.7	1	3,961.2	2	2,955.0	1	20,299.5	1	1	

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, батлуулж, тайлагнаагүй.	1	-					1	-
Дүн	1	-					1	-
Нийт дүн	1	-					1	-